



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛ


Төлбөрийн тэнцэл

2015 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр урсгал ба хөрөнгийн данс 833 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 788 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 268 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын албан нөөц уг дүнгээр буурчээ.

Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -223 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 966 сая ам.доллараар, санхүүгийн дансны ашиг 716 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




Гадаад хөрөнгө оруулалтын позиц (IIP)

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 3,907 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 32,539 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц жилийн эцэст 28,632 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй буюу богино байна.

Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулж байгаа бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 5% буюу 1,402 сая ам.доллараар өссөн.

Үүнд: шууд хөрөнгө оруулалтын богино позиц 437 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтынх 406 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтынх 185 сая ам.доллараар тус тус өсч, гадаад валютын улсын нөөцийн үлдэгдэл 327 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц




Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 22,718 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4%-иар буюу 867 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Үүнд:

- Засгийн газар болон Төв банкны гадаад өр өнгөрсөн оны мөн үеэс 32%-иар буюу 648 сая ам.доллараар өсч 5,720 сая ам.долларт,
- Хувийн хэвшлийн гадаад өр 16%-иар буюу 219 сая ам.доллараар өсч 16,998 сая ам.долларт хүрсэн байна.

Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

УРСГАЛ БОЛОН ХӨРӨНГИЙН ДАНС

2015 оны гүйцэтгэлээр урсгал ба хөрөнгийн тэнцлийн алдагдал – 833 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 53%-иар буюу 966 сая ам.доллараар буурчээ.

Үүнд, барааны гадаад худалдааны дансны ашиг 217%-иар буюу 385 сая ам.доллараар өсч, үйлчилгээний худалдааны алдагдал 45%-иар буюу 574 сая ам.доллараар буурсан нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 23%-иар буурч 8,330 сая ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд эерэг тэмдэгтэй 563 сая ам.долларт хүрч, 2 жил дараалан ашигтай гарлаа.

Үүнд хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашин, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Үйлчилгээний худалдаа

Үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн онтой харьцуулахад 45%-иар буурч 715 сая ам. долларт хүрсэн байна. Алдагдал буурахад тээврийн дансны тэнцэл 44%-иар буюу 84 сая ам.доллараар, аяллын дансных 32%-иар буюу 82 сая ам.доллараар, бусад үйлчилгээнийх 49%-иар буюу 408 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Бусад үйлчилгээний зардлын хамгийн их хувийг эзэлж байсан бизнесийн удирдлагын зөвлөх үйлчилгээний зардал 39%-иар буюу 221 сая, архитектур, инженер, техникийн үйлчилгээний зардал 30%-иар буюу 76 сая ам.доллараар буурсан байна.

Анхдагч орлого

2015 оны гүйцэтгэлээр анхдагч орлогын данс 970 сая ам.долларын алдагдалтай гарч 2014 оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 3 сая ам.доллараар буурсан байна.

Тайлант оны голлох төлбөрийг дурдвал,



- ААНБ-ууд гадаадын хөрөнгө оруулагчдад 176 сая ам.долларын ногдол ашгийг хуваарилж, хөрөнгө оруулагчдын зээлийн үүсвэрт 464 сая ам.долларын хүү төлсөн,
- Монгол Улсын Засгийн газар гадаад зээлийн эх үүсвэрт 22 сая ам.долларын хүү, ААНБ-ууд бусад гадаад зээлийн эх үүсвэрт 88 сая ам.долларын хүү,
- Банкууд гадаад зээл болон харьяат бусын харилцах, хадгаламжийн дансанд 23 сая ам.долларын хүү,
- Төр, хувийн хэвшил бондын эх үүсвэрт нийт 179 сая ам.долларын хүүгийн төлбөрийг тус тус төлсөн байна.

Хоёрдогч орлого

Энэ дансанд хувийн гуйвуулга болон хандив тусламжийн орлогыг бүртгэдэг бөгөөд 2015 онд манай улс цэвэр дүнгээр 174 сая ам.доллар буюу өнгөрсөн оноос 24 сая ам.доллараар их орлогыг хүлээн авсан байна. Үүнд:

- Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оноос 3%-иар өссөн,
- Гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 23%-иар буурснаар ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 45 сая ам.доллар болж 146%-иар өссөн дүнтэй байна.

Хүснэгт 1. Урсгал ба хөрөнгийн тэнцэл (сая ам.доллар)					
Үзүүлэлт	2014	2015	Өөрчлөлт		
			Дүн	Хувь	
I. Урсгал тэнцэл	-1,934	-948	986	51%	
1.1. Бараа	178	563	385	217%	
1.2. Үйлчилгээ	-1,289	-715	574	45%	
1.3. Анхдагч орлого	-973	-970	3	0%	
1.4. Хоёрдогч орлого	150	174	24	16%	
II. Хөрөнгийн тэнцэл	136	116	-20	-15%	
2.1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгө	0	0	0	0%	
2.2. Хөрөнгийн шилжүүлэг	136	116	-20	-15%	
Урсгал болон хөрөнгийн дансны тэнцэл	-1,799	-833	966	-54%	



Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)						
	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	60,934	29% ▲	18%	8,212	6% ▼	-29%
Америк	25,970	13% ▼	-44%	22,936	17% ▼	-28%
Хятад	14,426	7% ▼	-16%	26,435	20% ▼	-25%
Гонг Конг	7,581	4% ▲	16%	6,139	5% ▼	-50%
Англи	13,101	6% ▼	-31%	3,779	3% ▼	-24%
ОХУ	6,143	3% ▼	-29%	6,411	5% ▼	-32%
Сингапур	4,398	2% ▼	-10%	4,793	4% ▼	-28%
Швейцарь	3,924	2% ▼	-37%	4,888	4% ▲	116%
Герман	7,426	4% ▲	15%	3,352	3% ▼	-10%
Япон	6,550	3% ▲	53%	2,766	2% ▼	-64%
Бусад	56,289	27% ▲	85%	41,741	32% ▲	0%
НИЙТ	206,742	100%		131,451	100%	

Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (жилээр, сая ам.доллар)					
	2013	2014	2015	Өөрчлөлт	
				Мөнгөндүн	Хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	16.6	30.8	75.8	45.0	146.4%
Гаднаас орж ирсэн	211.3	201.4	207.2	5.9	2.9%
Гадагш шилжүүлсэн	194.7	170.6	131.5	-39.16	-23.0%

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

САНХҮҮГИЙН ДАНС

Санхүүгийн дансны тэнцэл 788 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 48%-иар буюу 716 сая ам.доллараар буурсан үзүүлэлт бөгөөд энэ нь Монгол Улсад орох бусад хөрөнгө оруулалтын санхүүжилт цэвэр дүнгээрээ өнгөрсөн оны мөн үеэс 64%-иар буюу 148 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын дансны тэнцэл 55%-иар буюу 547 сая ам.доллараар буурснаар тайлбарлагдаж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Тайлант хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр -83 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 148 сая ам.доллараар буурсан байна.

Үүнд аж ахуйн нэгж, байгууллагуудын гадны хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн санхүүжилтийн тэнцэл өнгөрсөн оноос 96%-иар буюу 365 сая ам.доллараар буурч, -0,7 сая ам.долларт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Банкны системээр дамжин орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалыг улсаар нь авч үзвэл, Гонг Конг-оос орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оноос 43%-иар өсч 119 сая ам.долларт, БНСУ-ын банкаар дамжин орж ирсэн хөрөнгө оруулалт 8%-иар өсч 31 сая ам.долларт хүрсэн бол ОХУ, БНХАУ, Германы банкуудаас орж ирсэн хөрөнгө оруулалт буурсан үзүүлэлттэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант хугацаанд 248 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны үзүүлэлтэй ойролцоо утгатай гарсан байна. 2015 онд Засгийн газар болон арилжааны банкууд нийт 500 сая ам.долларын нэрлэсэн үнэ бүхий бондыг олон улсын зах дээр арилжаалж, 325 сая ам.долларын бондыг буцаан төлсөн байна.

Бусад хөрөнгө оруулалт

Тайлант онд бусад хөрөнгө оруулалтын данс 455 сая ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал ашиг 547 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Энэ нь аж ахуйн нэгж, иргэдийн гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэр 374 сая ам.доллараар, харьяат бус ААНБ-уудад өгөх худалдааны өглөг 225 сая ам.доллараар буурснаас голлон шалтгаалжээ.



Алдаа ба орхигдуулга

Тайлант хугацаанд алдаа ба орхигдуулга үзүүлэлт -223 сая ам.доллар гарсан байна.

Уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд гадагш чиглэсэн хөрөнгийн урсгалын төлбөр тооцоо дутуу бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая ам.доллар)				
Үзүүлэлт	2014	2015	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
III. Санхүүгийн тэнцэл	-1,504	-788	716	48%
3.1. Шууд хөрөнгө оруулалт	-231	-83	148	64%
Гадагш хийсэн	107	11	-96	-89%
Монгол Улсад орсон	338	94	-243	72%
3.2. Багцын хөрөнгө оруулалт	-270	-248	21	8%
3.3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-1	-1	0	-23%
3.4. Бусад хөрөнгө оруулалт	-1,002	-455	547	-55%
Үүнээс: Худалдааны зээл	-72	191	264	364%
Бэлэн мөнгө харилцах	228	-329	-557	-244%

Хүснэгт 5. ГШХО, банкны системээр хийгдсэн (сая ам.доллар)					
№	Үзүүлэлт	2015		2015/2014	
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	Австрали	9	2%	3	▲
2	Америк	27	7%	8	▲
3	Англи	12	3%	4	▲
4	Бельги	1	0%	-4	▼
5	БНХАУ	97	24%	-7	▼
6	Герман	4	1%	-39	▼
7	Голланд	0	0%	10	▲
8	Гонг-Конг	119	30%	43	▲
9	Канад	3	1%	4	▲
10	Люксембург	0	0%	1	▲
11	Малайз	0	0%	-2	▼
12	ОХУ	4	1%	-1	▼
13	Сингапур	27	7%	14	▲
14	Солонгос (өмнөд)	31	8%	1	▲
15	Швейцарь	6	2%	-1	▼
16	Япон	33	8%	6	▲
17	Бусад	28	7%	-3	▼
Нийт		402.2	100%	37.2	▲



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2015 оны эцэст –28,632 сая ам.доллар байв.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 29 тэрбум ам.доллараар их байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, багцын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа ГШХО-тай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчаасаа татсан зээлийн санхүүжилтийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,907 сая ам.доллар байна. Үүний 34%-ийг гадаад валютын албан нөөц, 46%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 11%-ийг шууд хөрөнгө оруулалт, 3%-ийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл, үлдсэн 6%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад Гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 32,539 сая ам.долларт хүрчээ. Үүний 64%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 26%-ийг бусад хөрөнгө оруулалт, 1%-ийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл, үлдсэн 9%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 46% буюу 9,575 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 54% буюу 11,121 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 5%-иар буюу 1,402 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 3%-иар буюу 138 сая ам.доллараар буурч, гадаад пассив 4%-иар буюу 1,264 сая ам.доллараар өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, шууд хөрөнгө оруулалтын богино позиц 437 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 185 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 406 сая ам.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зах зээлийн үнэ


Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааны үнэ 2015 онд өмнөх жилийн хаалтын ханштай харьцуулахад дунджаар 25%-иар буурчээ.

Сентерра гоулд компанийн хувьцаа 9%-иар өсч 6.59 канад доллар, Петро матад компанийн хувьцаа 47%-иар өсч 3.13 фунт стерлинг болсон бол бусад компаниуд Тухайлбал, Оюутолгой, Харанга ресурс, Пийс Мап Холдинг, Монголиа Майнинг корпораци, Монголиа Энержи корпораци, Винсвэй Кокинг кол зэрэг компаниудын хувьцааны ханш уналттай байна.


Хүснэгт 7. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2014	12/31/2015	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-27,230	-28,632	1402	5%
I. Гадаад актив	4,045	3,907	-138	-3%
1. Шууд хөрөнгө оруулалт	427	440	12	3%
2. Багцын хөрөнгө оруулалт	217	223	6	3%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	121	114	-7	-5%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,630	1,807	177	11%
5. Нөөц актив	1,650	1,323	-327	-20%
II. Гадаад пассив	31,275	32,539	1264	4%
1. Шууд хөрөнгө оруулалт	20,247	20,696	449	2%
2. Багцын хөрөнгө оруулалт	2,877	3,067	191	7%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	124	166	41	33%
4. Бусад хөрөнгө оруулалт	8,027	8,610	583	7%

Дүрслэл 8. Гадаад актив



Дүрслэл 9. Гадаад пассив



Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ

№	Компанийн нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					12/31/2014	12/31/2015	
1	Turquoise Hill Resources	TRQ:US	US	USD	3.10	2.54	-18.1%
2	Mongolian Mining Corp	0975.HK	HK	HKD	0.34	0.18	-48.5%
3	Centerra Gold	CG.TO	CAD	CAD	6.04	6.59	9.1%
4	Southgobi Resources	1878.HK	HK	HKD	3.86	2.40	-37.8%
5	Winsway Cocking Coal	1733.HK	HK	HKD	0.25	0.15	-40.0%
6	Mongolia Energy Corp	0276.HK	HK	HKD	0.40	0.18	-55.8%
7	Petro Matad	MATD.L	LN	GBP	2.12	3.13	47.4%
8	Prophecy Coal Corp	PCY.TO	CAD	CAD	0.05	0.04	-20.0%
9	Haranga resources	HAR.AX	AU	AUD	0.01	0.00	-100.0%
10	Peace Map Holding Limited	0402.HK	HK	HKD	0.34	0.38	10.3%

III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2015 оны жилийн эцсийн байдлаар 22,718 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 867 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг салбараар нь авч үзвэл:

Улсын салбар: Засгийн газар, Монголбанкны гадаад өр 648 сая ам.доллараар нэмэгдэж 5,720 сая ам.долларт хүрчээ.

Хувийн хэвшил: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн жилийн хугацаанд 219 сая ам.доллараар өсч 16,998 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2015 оны эцэст 2,129 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 21%-иар буюу 366 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 61%-ийг зээл, 30%-ийг бонд, өрийн бичиг, үлдсэн 9%-ийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкууд тайлант онд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 294 сая ам.долларын урт хугацаат, 287 сая ам.долларын богино хугацаат зээлийг шинээр авч, гэрээний дагуу 158 сая ам.долларын урт, 225 сая ам.долларын богино хугацаат зээлийг буцаан төлснөөр зээлийн үлдэгдэл харгалзан 1,098 сая ам.доллар, 469 сая ам.долларт тус тус хүрээд байна.

Банкны бус салбар

Банк бус салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2015 оны эцэст 14,870 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 147 сая ам.доллараар буурсан.

Салбарын нийт зээлийн 75% буюу 11,121 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна. Эх үүсвэр нь компаний эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.


Хөрөнгө оруулагчдын санхүүжилтийн ашиглалт болон буцаан төлөлтийн байдлыг авч үзвэл тайлант онд харгалзан 888 сая ам.доллар, 889 сая ам.доллар байжээ.

ААНБ-уудын экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант оны эцсийн байдлаар 138 сая ам.доллар болсон байна.


Үзүүлэлт	12/31/2014	12/31/2015	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	21,851	22,718	867	4%	100%
I. Засгийн газар	3,501	3,760	259	7%	17%
II. Төв банк	1,570	1,960	389	25%	9%
III. Банк	1,762	2,129	366	21%	9%
Богино хугацаат	357	407	51	14%	2%
Урт хугацаат	1,406	1,721	315	22%	8%
IV. Бусад сектор	3,977	3,749	-228	-6%	17%
Богино хугацаат	555	326	-229	-41%	1%
Урт хугацаат	3,421	3,423	2	0%	15%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	11,041	11,121	80	1%	49%

*: Нийт өсөлтөд оруулсан хувь

Дүрслэл 10. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 11. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газрын гадаад өр: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: Монголбанк, ТТБГазар, ССГазар
3. Банк: Арилжааны банкуудын тайлан тэнцэл, Төлбөрийн тэнцлийн мэдээ, Гадаад зээлийн бүртгэл
4. Банк бус салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, Банкуудын гадаад гүйлгээний тайлан, Гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	Он			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2013	2014	2015	Дүн	2015/14	Дүн	2016/15
I. УРСГАЛ ДАНС	-4732	-1934	-948	2798	-59%	986	51%
Бараа ба үйлчилгээний худалдаа	-3,918	-1,111	-153	2,806	-72%	959	86%
Кредит	4,478	6,078	5,135	1,600	36%	-943	-16%
Дebet	8,396	7,189	5,288	-1,207	-14%	-1,901	-26%
1. Бараа	-2,608	178	563	2,786	-107%	385	217%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	3,789	5,471	4,446	1,681	44%	-1,024	-19%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	6,397	5,293	3,884	-1,104	-17%	-1,409	-27%
2. Үйлчилгээ	-1,310	-1,289	-715	21	-2%	574	45%
Кредит	689	607	689	-82	-12%	82	13%
Дebet	1,999	1,896	1,404	-102	-5%	-492	-26%
2.1 Тээвэр	-247	-190	-106	58	-23%	84	44%
Кредит	229	204	239	-25	-11%	34	17%
Дebet	477	394	345	-82	-17%	-50	-13%
2.2 Аялал	-383	-258	-176	125	-33%	82	32%
Кредит	197	215	246	18	9%	31	14%
Дebet	580	473	422	-107	-18%	-51	-11%
2.3 Бусад үйлчилгээ	-680	-841	-433	-162	24%	408	49%
Кредит	263	188	205	-75	-29%	17	9%
Дebet	942	1,029	638	87	9%	-391	-38%
3. Анхдагч орлого	-963	-973	-970	-10	1%	3	0%
Кредит	52	57	59	5	10%	2	3%
Дebet	1,015	1,030	1,028	15	1%	-1	0%
3.1 Ажилчдын цалин	-201	-113	-42	88	-44%	70	62%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-762	-860	-927	-98	13%	-67	-8%
3.3 Бусад	0	0	0	0	0%	0	0%
4. Хоёрдогч орлого	149	150	174	1	1%	24	16%
Кредит	355	333	320	-23	-6%	-12	-4%
Дebet	207	183	146	-23	-11%	-37	-20%
үүнээс: Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	38	35	26	-3	-7%	-9	-26%
Бусад байгууллага	111	115	148	3	3%	34	29%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	141	136	116	-5	-4%	-20	-15%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (Дт)/ бууралт (Кр)	0	0	0	0	0%	0	0%
Кредит	0	0	0	0	0%	0	0%
Дebet	0	0	0	0	0%	0	0%
2. Хөрөнгийн шилжүүлэг	141	136	116	-5	-4%	-20	-15%
Кредит	143	136	117	-7	-5%	-20	-14%
Дebet	2	1	1	-2	-64%	0	33%
0	0	0	0				
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-4,591	-1,799	-833	2,792	-61%	966	54%
III. САНХҮҮГИЙН ДАНС	-2808	-1504	-788	1304	-46%	716	48%
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-2,808	-1,504	-788	1,304	-46%	716	48%
1. Шууд хөрөнгө оруулалт	-2,019	-231	-83	1,788	-89%	148	64%
1.1 Актив	41	107	11	66	161%	-96	-89%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	38	104	10	67	177%	-94	-90%
1.1.2 Өрийн хэрэгсэл	3	3	1	-1	-17%	-1	-53%
1.2 Пассив	2,060	338	94	-1,722	-84%	-243	-72%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	364	-26	95	-390	-107%	122	459%
1.2.2 Өрийн хэрэгсэл	1,696	364	-1	-1,332	-79%	-365	-100%
2. Багцын хөрөнгө оруулалт	161	-270	-248	-431	-268%	21	8%
2.1 Актив	18	41	29	23	127%	-13	-30%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	18	38	34	19	106%	-4	-10%
2.1.2 Өрийн бичиг	0	4	-5	4	x29	-9	-243%
2.2 Пассив	-142	311	277	454	-319%	-34	-11%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	0	-3	0	-3	x63	3	102%
2.2.2 Өрийн бичиг	-142	315	277	457	-321%	-37	-12%
2.2.2.1 Богино хугацаат	0	0	0	0	0%	0	0%
2.2.2.2 Урт хугацаат	-142	315	277	457	-321%	-37	-12%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	0	-1	-1	-1	0%	0	0%
3.1 Актив	0	3	-1	3	0%	-4	0%
3.2 Пассив	0	4	1	4	0%	-4	0%
4. Бусад хөрөнгө оруулалт	-950	-1,002	-455	-52	5%	547	55%
4.1 Актив	625	306	233	-318	-51%	-73	-24%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0	0%	0	0%
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	647	227	237	-420	-65%	10	4%
4.1.3 Зээл	3	46	2	43	x14	-44	-97%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0	0%	0	0%
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-25	34	-5	59	-238%	-39	-114%
4.1.5.1 Богино хугацаат	-25	34	-5	59	-238%	-39	-114%
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0	0%	0	0%
4.1.6 Бусад авлага	0	0	0	0	0%	0	0%
4.2 Пассив	1,575	1,308	689	-266	-17%	-620	-47%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0	0%	0	0%
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	701	471	454	-230	-33%	-17	-4%
4.2.3 Зээл	830	751	349	-79	-9%	-402	-54%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0	5%	0	0%
4.2.3.2 Хадгаламжийн байгууллагууд	308	259	182	-49	-16%	-77	-30%
4.2.3.3.1 Богино хугацаат	145	93	55	-52	-36%	-38	-41%
4.2.3.3.2 Урт хугацаат	163	166	127	3	2%	-39	-23%
4.2.3.3 Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	153	139	189	-13	-9%	50	36%
4.2.3.4 Бусад салбар	369	352	-22	-16	-4%	-374	-106%
4.2.3.4.1 Богино хугацаат	-135	-78	-65	56	-42%	14	18%
4.2.3.4.2 Урт хугацаат	503	431	43	-73	-14%	-388	-90%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0	0%	0	0%
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	44	38	-186	-6	-13%	-225	-585%
4.2.5.1 Богино хугацаат	44	38	-186	-6	-13%	-225	-585%
4.2.5.2 Урт хугацаат	0	0	0	0	0%	0	0%
4.2.6 Бусад авлага	0	48	72	48	0%	24	0%
4.2.7 Зээлжих тусгай эрх /Урт хугацаат/	0	0	0	0	0%	0	0%
IV. Алдаа болон орхигдуулга	-84	-176	-223	-92	109%	-47	-27%
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-1,867	-471	-268	1,396	-75%	203	43%
V. НӨӨЦ ХӨРӨНГӨ	-1867	-471	-268	1396	-43%	203	43%
1. ГБУН	-1,960	-533	-271	1,427	-49%	262	49%
2. ОУВС-гийн зээл	-92	-62	-3	31	-96%	59	96%
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0	0%	0	0%

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (мянган ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015
Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	(6,489)	(12,314)	(19,238)	(24,642)	(27,230)	(28,632)
Актив	6,221	6,127	6,753	4,340	4,045	3,907
Шууд хөрөнгө оруулалт	2,616	1,757	883	351	427	440
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	2,595	1,704	817	282	355	366
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	2,595	1,704	817	282	355	366
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0
үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0
Өрийн хэрэгсэл	20	54	66	69	72	73
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	20	54	66	69	71	72
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	1	1
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	359	202	485	370	217	223
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	308	196	479	365	208	213
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	3	2	3
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	308	196	479	362	206	210
Бусад санхүүгийн байгууллага	4	32	77	92	129	163
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	304	165	402	270	76	47
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	51	6	6	6	9	10
Төв банк	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	0	0	0	0	0	6
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	6
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	51	6	6	6	9	4
Богино хугацаат	6	6	6	6	6	0
Урт хугацаат	45	0	0	(0)	3	4
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0
Богино хугацаат	6	6	6	6	6	0
Урт хугацаат	0	0	0	0	3	4
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	45	(0)	(0)	(0)	(0)	(0)
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	0	1	0	49	121	114
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	1	0	49	121	114
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	959	1,318	1,259	1,404	1,630	1,807
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	839	1,033	896	1,100	1,225	1,443
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	503	500	530	489	311	441
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	335	533	366	611	913	1,002
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0
Зээл	18	14	15	6	49	50
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	18	9	15	2	47	49
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	5	0	3	2	1
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	5	0	3	2	1
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	101	271	348	298	357	314
Бусад дансны авлага/оглөг	0	0	0	0	0	0
Нөөц хөрөнгө	2,288	2,847	4,126	2,166	1,650	1,323

Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015
Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	(6,489)	(12,314)	(19,238)	(24,642)	(27,230)	(28,632)
Өр төлбөр	12,711	18,440	25,991	28,981	31,275	32,539
Шууд хөрөнгө оруулалт	8,445	13,333	17,668	19,579	20,247	20,696
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	5,459	7,380	8,641	8,989	9,206	9,575
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	5,459	7,380	8,641	8,989	9,206	9,575
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0
Өрийн хэргэсэл	2,986	5,953	9,028	10,590	11,041	11,121
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	2,986	5,953	9,028	10,590	11,041	11,121
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	487	564	2,895	2,494	2,877	3,067
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	124	151	140	114	94	80
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	11	11	11	11	11	11
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	113	140	129	103	83	69
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	364	413	2,755	2,380	2,783	2,987
Төв банк	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	242	258	547	400	522	652
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	242	258	547	400	522	652
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	114	127	1,587	1,415	1,403	1,473
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	114	127	1,587	1,415	1,403	1,473
Бусад салбарууд	8	28	621	565	858	862
Богино хугацаат	0	0	0	0	0	2
Урт хугацаат	8	28	621	565	858	860
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	0	1	0	49	124	166
Төв банк	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	1	0	49	124	166
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	3,779	4,542	5,427	6,859	8,027	8,610
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	35	130	480	1,151	1,590	1,954
Төв банк	0	0	337	990	1,449	1,772
Богино хугацаат	0	0	337	990	1,449	1,772
Урт хугацаат	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	35	130	143	161	141	182
Богино хугацаат	0	0	0	0	0	0
Урт хугацаат	35	130	143	161	141	182
үүнээс: Банк хоорондын позиц	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0
Зээл	3,564	4,063	4,559	5,275	5,965	6,398
Төв банк	274	268	235	141	73	68
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	235	352	486	815	1,100	1,294
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	1,769	1,917	2,012	2,119	2,098	2,287
Бусад салбарууд	1,287	1,526	1,826	2,200	2,694	2,749
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	180	350	389	433	424	138
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	48	120

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015
Засгийн газар	1,882.2	2,043.3	3,599.3	3,534.6	3,500.8	3,759.9
Төвбанк	273.6	267.7	571.5	1,130.5	1,570.4	1,959.6
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	512.0	739.8	1,176.0	1,375.8	1,762.2	2,128.5
Бусад салбарууд	1,474.3	1,904.7	2,836.1	3,198.7	3,976.6	3,748.9
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	2,985.7	5,952.8	9,027.6	10,590.1	11,040.6	11,120.9
Нийт гадаад өр	7,127.8	10,908.3	17,210.5	19,829.7	21,850.5	22,717.8

Эх сурвалж: Монголбанк